



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Төмөртөгоогийн ЭНХТҮВШИН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-29-80, Факс: 32-70-16
E-mail: enkhtuvshint@parliament.mn
<http://www.parliament.mn>

2024.03.21 № УЧХ-03/2069
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл
өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Т.ЭНХТҮВШИН
С.БЯМБАЦОГТ

000093



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Төмөртөгоогийн ЭНХТҮВШИН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-29-80, Факс: 32-70-16
E-mail: enkhtuvshint@parliament.mn
<http://www.parliament.mn>

2024.03.20 № УИХ-03/2059

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга болон холбогдох материалыг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Т.ЭНХТҮВШИН

С.БЯМБАЦОГТ

000096



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Төмөрготоогийн ЭНХТҮВШИН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-29-80, Факс: 32-70-16
E-mail: enkhtuvshint@parliament.mn
<http://www.parliament.mn>

2023.11.09 № УИХ-03/8922

танай _____-ны № _____-т


Санал авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын санал, дүгнэлтийг авахаар хүргүүлж байна.

Иймд уг хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.11 дэх хэсэгт заасны дагуу саналаа ирүүлнэ үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, холбогдох материалыг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Т.ЭНХТҮВШИН

С.БЯМБАЦОГТ

000265

**БАТЛАВ.
ХУУЛЬ САНААЧЛАГЧ**

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Т.ЭНХТҮВШИН**

**ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**

ТУС3764 9023051393 9087184

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулж, хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт, татварын таатай орчинг бий болгох, улмаар гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэхээр Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиар Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар нэг удаа сунгах шийдвэрийг Засгийн газарт олгосон.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн “Гаалийн албан татвараас чөлөөлөгдөх барааны жагсаалт” гэсэн 38 дугаар зүйлийн 38.1.20 дахь заалт болон “Гаалийн болон бусад албан татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлөх” гэсэн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсгийн зохицуулалтыг хугацаагүй гаалийн татвараас чөлөөлөх барааг зохицуулсан уг хуулийн 38 дугаар зүйлд нийцүүлэх, хууль хэрэглээг тодорхой болгох зорилгоор хуулийн төслийг боловсруулсан.

Хоёр.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл 2 заалттай. Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгж өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэж, үндсэн үйл ажиллагаандаа ашигласан барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас бүрэн чөлөөлж, паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар нэг удаа сунгах шийдвэрийг Засгийн газарт олгох.

Гурав.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагаврын талаар:

Хуулийн төсөл батлагдсанаар Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаанд төрөөс бодлогын болон бусад шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх хууль эрх зүйн орчин бүрдэж, хөрөнгө оруулалт, татварын таатай орчин бий болж, гадаад дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэн үйлдвэрлэлийг цогцолбороор нь хөгжүүлэх боломж бүрдэнэ.

Дөрөв.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт орох хуулиуд:

Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцэж байгаа бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр хуульд нэмэлт, өөрчлөлт орохгүй бөгөөд дагалдах хууль батлахгүй.

ХУУЛИЙН ТӨСӨЛ САНААЧЛАГЧ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.20 дахь заалтын “үйлдвэрлэл,” гэсний өмнөх “энэ хуулийн 40.4-т заасны дагуу татвар төлөх хугацааг сунгасан хугацаанд” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсгийн “нэмэгдсэн” гэсний өмнөх “гаалийн болон” гэснийг хассугай.

Гарын үсэг

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Гаалийн тариф, гаалийн татварын тухай
хуульд хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл*

Үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулахад Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиар Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжид гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэхээр зохицуулсан байдаг.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн “Гаалийн албан татвараас чөлөөлөгдөх барааны жагсаалт” гэсэн 38 дугаар зүйлийн 38.1.20 дахь заалт болон “Гаалийн болон бусад албан татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлөх” гэсэн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсгийн зохицуулалтыг гаалийн татвараас хугацаагүй чөлөөлөх барааг зохицуулсан уг хуулийн 38 дугаар зүйлд нийцүүлэн хууль хэрэглээг тодорхой болгох зорилгоор хуулийн төслийг боловсруулсан.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 2 зүйлтэй.

Хуулийн төсөлд дараах өөрчлөлтийг тусгалаа. Үүнд:

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн “Гаалийн албан татвараас чөлөөлөгдөх барааны жагсаалт” гэсэн 38 дугаар зүйлийн 38.1.20 дахь заалтад өөрчлөлт оруулан үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгж өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэж үндсэн үйл ажиллагаандаа ашигласан барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмж гаалийн албан татвараас хугацаагүй чөлөөлөх.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлээр Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн “Гаалийн болон бусад албан татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлөх” гэсэн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсэгт өөрчлөлт оруулан Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар нэг удаа сунгах шийдвэрийг Засгийн газар гаргахаар зохицуулсан.

Хуулийн төсөл батлагдсанаар Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаанд төрөөс бодлогын болон бусад шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх хууль эрх зүйн орчин бүрдэж, хөрөнгө оруулалт татах эрх зүйн таатай орчин бий болж, гадаад дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэн үйлдвэрлэлийг цогцолбороор нь хөгжүүлэх боломж бүрдэнэ.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

*Гаалийн тариф, гаалийн татварын тухай
хуульд хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл*

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн орчин, хөрөнгө оруулалт, татварын таатай орчинг бий болгох, улмаар гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татаж, шинээр ажлын байр бий болгох, нарийн технологид суурилсан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор Улсын Их Хурлаас “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг 2022 онд баталсан.

Уг хуулиар улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд онцгой ач холбогдолтой импортыг орлох, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний хэмжээний төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, байгаль орчинд ээлтэй, шинэ, дэвшилтэт болон өндөр технологи дамжуулах, нэвтрүүлэх, нутагшуулах, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй үйлдвэрлэлийг хөгжүүлэх, улсын болон бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих орчныг бүрдүүлэх, ажлын байр бий болгох зорилгоор үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулахаар зохицуулсан.

Үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулахад Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиар Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжид гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэхээр зохицуулсан байдаг.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн “Гаалийн албан татвараас чөлөөлөгдөх барааны жагсаалт” гэсэн 38 дугаар зүйлийн 38.1.20 дахь заалт болон “Гаалийн болон бусад албан татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлөх” гэсэн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсгийн зохицуулалтыг гаалийн татвараас хугацаагүй чөлөөлөх барааг зохицуулсан уг хуулийн 38 дугаар зүйлд нийцүүлэн хууль хэрэглээг тодорхой болгох зорилгоор хуулийн төслийг боловсруулсан.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 2 зүйлтэй.

Хуулийн төсөлд дараах өөрчлөлтийг тусгалаа. Үүнд:

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн “Гаалийн албан татвараас чөлөөлөгдөх барааны жагсаалт” гэсэн 38 дугаар зүйлийн 38.1.20 дахь заалтад өөрчлөлт оруулан үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгж өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэж үндсэн үйл ажиллагаандаа ашигласан барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмж гаалийн албан татвараас хугацаагүй чөлөөлөх.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлээр Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн “Гаалийн болон бусад албан татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлөх” гэсэн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсэгт өөрчлөлт оруулан Үйлдвэрлэл,

технологийн паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар нэг удаа сунгах шийдвэрийг Засгийн газар гаргахаар зохицуулсан.

Хуулийн төсөл батлагдсанаар Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаанд төрөөс бодлогын болон бусад шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх хууль эрх зүйн орчин бүрдэж, хөрөнгө оруулалт татах эрх зүйн таатай орчин бий болж, гадаад дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэн үйлдвэрлэлийг цогцолбороор нь хөгжүүлэх боломж бүрдэнэ.

Гаалийн тариф, гаалийн татварын хуулийн 40.6-д заасныг үндэслэн "Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам"-ыг Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр баталсан бөгөөд одоогоор дээрх татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан татвар төлөгч байхгүй бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

---o0o---

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.14-т “уул уурхайн ордыг ашиглалтад оруулж, өндөр технологийн хүнд үйлдвэрийн нүүрс-хими, нүүрс-эрчим хүч, метан хийн үйлдвэрлэл, технологийн паркийг барьж байгуулах”, 8.1.9-т “хөгжлийн ирээдүйтэй суурин газарт бүс нутгийн онцлог, нүүдлийн мал аж ахуйд тулгуурлан хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн 33 паркийг бүсчлэн байгуулах” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 8.3.12-т “малын гаралтай түүхий эд боловсруулах, экспортлох үйлдвэр, технологийн парк байгуулж, ажлын байрыг шинээр бий болгож, малчдын орлогыг өсгөнө”, 9.5.4-т “дагуул хотуудад дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ” гэж заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1.6-д “Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулна”, 3.2.7.2-т “Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн үйлдвэрлэл, технологийн парк байгуулна. Паркийн бүрэлдэхүүнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр болон исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологиор катодын зэсийн үйлдвэр байгуулна”, 6.1.11-д “дагуул хотуудад дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ” гэж заасан.

Эрх зүйн орчны хүрээгээр авч үзвэл уг асуудлыг Монгол улсын Үндсэн хууль, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохицуулж байна.

Үзэл баримтлалын хувьд тус хуулиар паркийн үйл ажиллагааг удирдан зохицуулах асуудал нэгдсэн бодлого төлөвлөлттэй болж, үйлдвэрлэлийн хүчин зүйлсийг тодорхой байршилд төвлөрүүлэн, дэд бүтцийн төвлөрсөн хангамж бий болж, паркийн үйл ажиллагаанд төрөөс бодлогын болон бусад шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх юм. Түүнчлэн, хөрөнгө оруулалт татах эрх зүйн таатай орчин бий болж, гадаад дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэх, сургалт, судалгаа, шинжилгээний үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, шинэ дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж нутагшуулах, технологийн тасралтгүй хөгжлийг хангах үйл ажиллагааны талаарх зохицуулалтууд бий болж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд техник технологийн дэвшлийг ашиглах нөхцөл бүрдэх, үйлдвэрлэлийг цогцолбороор нь хөгжүүлснээр бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэсгэх, дагалдах жижиг, дунд үйлдвэр, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ.

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд тусгагдсан төрийн дэмжлэгийг тодорхойлж, хөрөнгө оруулалт татах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль болон Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулиар үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэгчдийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг зохицуулсан.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлээр гаалийн татвараас чөлөөлөгдөх барааны жагсаалтыг, мөн хуулийн 40 дүгээр зүйлээр гаалийн болон бусад татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлөх харилцааг зохицуулсан байдаг.

Дээрх хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.20-д “энэ хуулийн 40.4-т заасны дагуу татвар төлөх хугацааг сунгасан хугацаанд үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгж өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэж үндсэн үйл ажиллагаандаа ашигласан барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмж.” гэж тусгасан нь үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгж өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэж үндсэн үйл ажиллагаандаа ашигласан барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийг зөвхөн татвар төлөх хугацааг сунгасан хугацаанд буюу 4-н жилийн хугацаанд чөлөөлөхөөр байгаа нь паркийн үйл ажиллагаа эрхлэгчдэд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхлээгүй байхад татварын дарамт үүсгэх нөхцөл бүрдэж байна.

Мөн хуулийн 40.4-т “Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар нэг удаа сунгах шийдвэрийг Засгийн газар гаргаж болно.” гэж тусгасан байна.

Дээрх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газраас “Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам”-ыг 2023 оны 337 дугаар тогтоолоор баталж, хэрэгжүүлж байна.

Уг тогтоолын 4.1.12-т “Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжтэй энэ журмын дагуу байгуулсан гэрээнд заасан барааг Засгийн газраас тогтоосон хугацаанд өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэж үндсэн үйл ажиллагаандаа ашигласан бол гаалийн байгууллага Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38.1.20-д заасны дагуу гаалийн татвараас чөлөөлнө.” гэж заасан.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын¹/цаашид Аргачлал гэх/ 2.1-д заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль нь 2008 онд батлагдсан бөгөөд өнөөдрийг хүртэлх хугацаанд 40 гаруй удаа нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурал баталсан байна.

¹Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйл /Гаалийн татвараас чөлөөлөгдөх бараа/-ийн 38.1.20 дахь заалтад заасныг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газраас “Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам”-ыг 2023 оны 337 дугаар тогтоолоор баталсан байна.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлээр гаалийн нутаг дэвсгэрт оруулах гаалийн татвараас чөлөөлөх барааны жагсаалтыг баталсан байдаг боловч тус зүйлийн 38.1.20 дахь заалтад “энэ хуулийн 40.4-т заасны дагуу татвар төлөх хугацааг сунгасан хугацаанд үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгж өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэж үндсэн үйл ажиллагаандаа ашигласан барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмж.” гэж тусгасан нь үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэгдэж, үндсэн үйл ажиллагаандаа ашиглах барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн гаалийн албан татварыг бүрэн чөлөөлөхгүй, тус хуулийн 40.4 дэх хэсэгт заасан хугацаанд буюу 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр ойлгогдож байна.

Мөн хуулийн 40 дүгээр зүйл “Гаалийн болон бусад татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлөх”-ийн 40.4 дэх хэсэгт “Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар нэг удаа сунгах шийдвэрийг Засгийн газар гаргаж болно.” гэж заасан нь тус хуулийн 38.1.20-д тусгагдсан паркийн зориулалттай барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн гаалийн албан татварыг 4 хүртэлх жилийн хугацаагаар сунгахаар зохицуулагдсан нь үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн бүрдэж, хөрөнгө оруулалт, татварын таатай орчин бий болж улмаар гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татаж, шинээр ажлын байр болох, нарийн технологид суурилсан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, гадаад зах зээлд өрсөлдөх чадвар сайжирна гэсэн зорилгодоо хүрэхгүй байна.

Иймд Аргалчлалын 3-д заасны дагуу дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлын улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, улмаар түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Иймд Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараахь байдлаар тодорхойлж байна.

Хуулийн төслийг боловсруулах зорилго нь Монгол Улсын иргэний Үндсэн хуульд заасан эрхийг бүрэн эдлүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад оршино.

**ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН
ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг судалж, аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу “үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгж өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэж үндсэн үйл ажиллагаандаа ашигласан барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмж”-ийг гаалийн албан татвараас чөлөөлж, мөн “Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар нэг удаа сунгах шийдвэрийг Засгийн газар гаргаж болно.” гэсэн зорилгыг хангаж чадах эсэх, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч, сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Зорилгыг хангах боломжгүй.	Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлөх боломжтой	Тодорхой үр дүнд хүрэхгүй
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Зорилгыг хангах шаардлагагүй		шаардлагагүй
4	Төрөөс санхүүгийн интервенци хийх	Зорилгыг хангах шаардлагагүй		шаардлагагүй
5	Захиргааны шийдвэр гаргах	Зорилгыг хангах боломжгүй. Хуулиар тогтоосон асуудлыг захиргааны шийдвэрээр өөрчлөх боломжгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй .	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Хуульд нэмэлт оруулах замаар зорилгыг хангах боломжтой.	Энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг	Үр дүнтэй

		шийдвэрлэх боломжтой.	
--	--	--------------------------	--

Асуудлын мөн чанар, цар хүрээг харгалзан үзсэний үндсэн дээр Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах хэлбэрээр хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь хүний эрхэд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй бөгөөд харин хүний эрхийг хангах, хамгаалах хэрэгцээ, шаардлага байна. Иймд эдгээр асуудлыг цогцоор шийдвэрлэхийн тулд хуульд нэмэлт оруулах төсөл боловсруулах нь зүйтэй болно.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц, бүтээн байгуулалтад шаардлагатай хөрөнгө оруулалтыг төрөөс татварын бодлогоор дэмжиж байгаа нь үйлдвэрлэл кластерээр хөгжих боломж бүрдэж, хөрөнгө оруулалт татах таатай орчин бий болж, гадаад дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ. Ингэснээр үйлдвэрлэл кластераар хөгжих боломж бүрдэх бөгөөд улмаар Монгол Улсын үйлдвэрлэлийн салбарын өрсөлдөх чадвар нэмэгдэх юм.

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин үйлдвэрлэлийг цогцолбороор нь хөгжүүлснээр бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэсгэх, дагалдах жижиг, дунд үйлдвэр, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих орчин бүрдэнэ.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа болно. Мөн энэ чиглэлээр хууль боловсруулахаар сонгосон хувилбар нь олон улсын хэм хэмжээний жишигтэй нийцэж байна. Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад нийцэж байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Иймд Гаалийн тариф, гаалийн татварын хуульд оруулах шаардлагатай байгаа асуудлыг тусгахын тулд хуульд өөрчлөлт оруулах хэлбэрээр хуулийн төсөл боловсруулж батлан гаргах хувилбар нь тавьсан зорилтыг хангахаар байна.

-----oOo-----

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэхүү үнэлгээг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт тухай хуулийн төсөл /цаашид “Хуулийн төсөл” гэх/-д Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад зөвлөмж өгөх зорилгоор хийлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.3-т заасан хуульд өөрчлөлт оруулах төрлөөр боловсруулагдсан хувилбар байв. Хуулийн төсөл нь 3 зүйлээс бүрдэж байгаа.

Иймээс хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг хуулийн төсөлд бүхэлд нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал-д /цаашид “аргачлал” гэх/ заасны дагуу хийлээ.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд заасны дагуу 6 шалгуур үзүүлэлтээс 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Харилцан уялдаа зэрэг болно.

“**Зорилгод хүрэх байдал**” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгов.

“**Ойлгомжтой байдал**” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь хуульд нэмэлт оруулах төсөл тул түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд болон хэл зүй, найруулгын хувьд ойлгомжтой боловсруулагдсан эсэхийг Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах үүднээс үнэлэхийг зорьж сонголоо.

“**Хүлээн зөвшөөрөх байдал**” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээдүүд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг

шалгана. Өөрөөр хэлбэл тусгайн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэхийг шалгана.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь хуульд нэмэлт оруулах төсөл тул хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд болон хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо нийцсэн эсэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг шалган тогтоож, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулах үүднээс хуулийн төслийг бүхэлд нь Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултуудад хариулах замаар үнэлэхээр сонгосон болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийв.

Хуулийн төслийг боловсруулахдаа үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгж өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэж үндсэн үйл ажиллагаандаа ашигласан барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлөх, мөн нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар нэг удаа сунгах шийдвэрийг Засгийн газраас баталсан журмаар зохицуулах асуудлыг тодорхой болгохоор өөрчлөлт оруулж байгаа.

Иймд энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд үнэлгээ хийхээр сонгож авлаа.

1 дүгээр зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.20 дахь заалтын “үйлдвэрлэл,” гэсний өмнөх “татвар төлөх хугацааг сунгасан хугацаанд” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсгийн “нэмэгдсэн” гэсний өмнөх “гаалийн болон” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

/Хуулийн төсөл 2 зүйлтэй./

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгах үүднээс хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

/Хуулийн төсөл 2 зүйлтэй./

ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг шалгах байдлаар <u>ойлгомжтой</u> байдлыг шалгах.
3	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төслийн үзэл баримтлалаас харахад Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлээр гаалийн татвараас чөлөөлөгдөх барааны жагсаалтыг, мөн хуулийн 40 дүгээр зүйлээр гаалийн болон бусад татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлөх харилцааг зохицуулсан байдаг.

Дээрх хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.20-д “энэ хуулийн 40.4-т заасны дагуу татвар төлөх хугацааг сунгасан хугацаанд үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгж өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэж үндсэн үйл ажиллагаандаа ашигласан барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмж.” гэж, 40.4-т “Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн гаалийн болон

нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар нэг удаа сунгах шийдвэрийг Засгийн газар гаргаж болно.” гэж тусгасан байна.

Дээрх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газраас “Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам”-ыг 2023 оны 337 дугаар тогтоолоор баталж, хэрэгжүүлж байна.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлээр гаалийн нутаг дэвсгэрт оруулах гаалийн татвараас чөлөөлөх барааны жагсаалтыг баталсан байдаг боловч тус зүйлийн 38.1.20 дахь заалтад “энэ хуулийн 40.4-т заасны дагуу татвар төлөх хугацааг сунгасан хугацаанд үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгж өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэж үндсэн үйл ажиллагаандаа ашигласан барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмж.” гэж тусгасан нь үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэгдэж, үндсэн үйл ажиллагаандаа ашиглах барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн гаалийн албан татварыг бүрэн чөлөөлөхгүй, тус хуулийн 40.4 дэх хэсэгт заасан хугацаанд буюу 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр ойлгогдож байна.

Иймд хуулийн дээрх заалтуудыг нэмж тодруулах, хууль хэрэглээг ойлгомжтой болгох, мөн хуулийн холбогдох зүйл, заалтуудтай нийцүүлэх хэрэгцээ шаардлага гарч байгаа нь үнэлгээ хийхээр сонгож авсан зохицуулалтын хувьд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагад нийцэж, хуулийн төслийн зорилтыг хангах боломжтой байна.

“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.

29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Зөрчилгүй.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлага хангасан.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Шаардлага хангасан.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлагагүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараахь стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорьлоо.

Д/д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Хуульд оруулж байгаа нэмэлт нь хуулийн зорилттой нийцэж байгаа харилцааг зохицуулахад оршино.
2	хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
3	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Нийцэж байгаа.
5	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Давхардсан зүйлгүй.
6	хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй.
7	хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй.
8	төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Үгүй.
9	татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй
10	тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Хуулийн төсөлд тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
11	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй.
12	хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөл нь жендерийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
13	хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
14	хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
15	хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хуулийн төсөлд хориглосон хэм хэмжээ тусгаагүй тул шаардлагагүй.

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1.Баримтжуулалт

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд ашигласан дараах баримт бичиг, мэдээлэл, тоо баримтыг цуглуулан үр нөлөөг тооцох ажиллагааны тайланд баримтжуулж хавсаргалаа.

1.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төслийн үзэл баримтлал, танилцуулга, холбогдох материал;

5.2.Дүгнэлт

Хуулийн төслийг сонгон авсан шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах дүгнэлтийг хийлээ.

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийж, дараах дүгнэлтэд хүрсэн.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн хувьд хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж зорилгод хүрэх байдлаар томъёологдсон байна.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан байна.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгасан.

Харилцан уялдаатай байдлыг хангасан.

5.3.Зөвлөмж

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлж холбогдох зөвлөмжийг хууль санаачлагчид өгсөн болно.

